

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.100

|                                                                                               |                             |
|-----------------------------------------------------------------------------------------------|-----------------------------|
| Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага | MNS 4968:XXX                |
| Occupational safety and health. General requirements for industrial operations.               | MNS MNS 4968:2000 -ын оронд |

Стандарт, хэмжил зүйн газрын даргын ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь ... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

### 1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь аж ахуйн нийт салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд тавих аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл ахуйн ерөнхий шаардлагыг тогтооно.

### 2 Ерөнхий зүйл

#### 2.1 Зорилго

Ажлын байранд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсэн шаардлагыг тогтоож, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажлын орчны аюулгүй байдлыг хангахад оршино

### 3 Зарчим

3.1 Үйлдвэрлэл, үйлчилгээ явагдах бүх хугацааны туршид үйлдвэрлэлийн үйл ажиллагааны аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл ахуй нь :

3.1.1 Технологийн арга барил

3.1.2 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг сонгох түүнийг ажиллуулах, үйлчлэх журам

3.1.3 Үндсэн ба туслах материал, хагас, бэлэн бүтээгдэхүүн, бэлдэц бүтээгдэхүүний зэхэлт, оролт, гаралт

3.1.4 Үйлдвэрлэлийн болон ажлын байр, түүний гадна орчин, ажил гүйцэтгэх үйлдвэрлэлийн талбайн эмх цэгц

3.1.5 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, ажлын байрны зохион байгуулалт

3.1.6 Үндсэн ба туслах материал, бэлдэц, хагас бэлэн ба бэлэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн хаягдлыг хадгалж, тээвэрлэх, өргөж зөөх арга

3.1.7 Хамгаалах хэрэгсэл

- 3.1.8 Хэрэглэж буй хими, биологийн бодисыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах арга
- 3.1.9 Гал гарах болон тэсэрч дэлбэрэх аюулаас урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл зэргийг зөв сонгосноор хангагдана.

#### 4 **Аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл ахуйн ерөнхий шаардлага**

##### 4.1 Технологийн арга барилд тавих шаардлага

- 4.1.1 Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг төлөвлөх зохион байгуулах үед ажилтны эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, түүний нөлөөллийг бууруулахад чиглэсэн иж бүрэн арга хэмжээг дараахь замаар тусган хэрэгжүүлсэн байвал зохино. Үүнд:
- Үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйл үүсгэх технологийн үйл ажиллагааг аюулгүй, хоргүй технологийн үйл ажиллагаагаар солих, шинэчлэх
  - Хамгаалах хэрэгслийг зөв сонгох
  - Үйлдвэрлэлийн аюултай ба хортой зүйлийн эх үүсвэр болон үйлдвэрлэлийн хаягдлыг нэн даруй зайлуулах, аюулгүй хоргүй болгох
  - Технологийн үйл ажиллагааны явцад аль нэг хэсэгт үүссэн үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлийн талаар цаг тухайд нь мэдээлэх, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг аюул осол гарах үед ажилтныг хамгаалж чадах удирдлага, хяналт зохион байгуулалтын системийг хэрэглэх
  - Ажлын ачааллыг хэт хүндрүүлэх, нэмэгдүүлэхээс урьдчилан сэргийлэх, ажил амралтын оновчтой дэглэм тогтоох
- 4.1.2 Технологийн үйл ажиллагаанд тавих аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл ахуйн шаардлага нь технологийн баримт бичигт тусгагдсан байна.
- 4.2 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг сонгох, түүнийг ажиллуулах үйлчлүүлэх журамд тавих шаардлага.
- 4.2.1 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан, аюулгүй ажиллагааны зөвшөөрөл, гэрчилгээтэй байна.
- 4.2.2 Тоног төхөөрөмжүүд нь түүнийг ажиллуулах, үйлчилгээ хийх үед мөрдөх аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл ахуйн заавар, дүрэмтэй байна
- 4.2.3 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь Монгол улсын стандарт “Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага”-ыг хангасан байна.

- 4.3 Үндсэн ба туслах материал, хагас ба бэлэн бүтээгдэхүүн, бэлдэц, бүтээгдэхүүний зэхэлт, оролт, гаралтад тавих шаардлага
  - 4.3.1 Үндсэн ба туслах материал, бэлдэц, хагас ба бэлэн бүтээгдэхүүн нь ажилтны эрүүл мэндэд аюултай ба хортой нөлөө үзүүлэхээргүй байна.
  - 4.3.2 Аюултай туслах ба туслах материал, бэлдэц, хагас бэлэн бүтээгдэхүүнийг хэрэглэх зайлшгүй шаардлагатай үед ажилтанд энэ талын заавар өгч сургалтад хамруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, мэдлэг, дадал чадварыг эзэмшүүлэх, шаардлага хангасан хамгаалах хэрэгслээр хангасан байна.
  - 4.3.3 Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлэх, бүтээгдэхүүний зэхэлт, оролт, гаралтын үйл ажиллагаа нь тус бүрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл ахуйн заавар дүрэмтэй байна.
- 4.4 Үйлдвэрлэлийн болон ажлын байр, үйлдвэрлэлийн гадна ажил гүйцэтгэх, талбайн эмх цэгцэд тавих шаардлага
  - 4.4.1 Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдах үйлдвэрлэлийн болон ажлын байр, талбай нь тухайн үйл ажиллагааны онцлогт тохируулсан, аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.
  - 4.4.2 Ажил гүйцэтгэх үйлдвэрлэлийн талбайн эмх цэгц нь ажилтныг ажил үүрэг гүйцэтгэхэд аваар осол гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 4.5 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, ажлын байрны зохион байгуулалтад тавих шаардлага
  - 4.5.1 Үйлдвэрлэлийн болон ажлын байр, талбайд тоног төхөөрөмжийг зам харилцааны хэрэгсэл, үндсэн ба туслах материал, бэлдэц, хагас бэлэн ба бэлэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн хаягдлыг аюултай ба хортой хүчин зүйл үүсгэхгүй байхаар байрлуулсан байна.
  - 4.5.2 Үйлдвэрлэлийн болон ажлын байрны зохион байгуулалт нь үйлдвэрлэлийн тухайн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, ажлын байранд тавих улсын стандартаар тогтоогдсон эргономикийн болон аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл ахуйн шаардлагыг хангаж байвал зохино.
- 4.6 Үндсэн ба туслах материал, бэлдэц, хагас бэлэн ба бэлэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн хаягдлыг хадгалж, тээвэрлэх, өргөж зөөх аргад тавих шаардлага
  - 4.6.1 Хадгалах үед дараах шаардлагыг хангасан байна. Үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлийг үүсгэхгүй хадгалах аргыг хэрэглэх; Аюулгүй ажиллагаа,

хөдөлмөрийн эрүүл ахуйн шаардлага хангасан хадгалах төхөөрөмж, байр хэрэглэх;

- 4.6.2 Тээврийн болон өргөж зөөх механизм нь аюулгүй ажиллагааны болон эргономикийн шаардлагыг хангаж, баталгаажилт хийгдсэн байна.
- Аюулгүй ажиллагааны шаардлага хангасан зам харилцааны хэрэгслийг ашиглах;
  - Өргөж зөөх, ачиж буулгах ажлыг механикжуулсан, автоматжуулсан байвал зохино

## **5 Хамгаалах хэрэгсэлд тавих шаардлага**

- 5.1 Хамгаалах хэрэгслийг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны онцлогт тохируулан түүний зориулалт, ангиллын дагуу сонгон авна.
- 5.2 Хамгаалах хэрэгсэл нь үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлийг үйлдвэрлэлийн болон ажлын бүснээс арилгах эсвэл түүний хэмжээг аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартын зохих түвшинд хүртэл бууруулж байвал зохино
- 5.3 Хамгаалах хэрэгсэл нь гарч болзошгүй сөрөг хүчин зүйлээс ажилтныг хамгаалах нөхцөлийг хангасан байна.

## **6 Хэрэглэж буй хими, биологийн бодисыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үед тавих шаардлага**

- 6.1 Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрэглэж буй хими, биологийн бодисыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үеийн дүрэм заавар, журам, стандартыг өөрийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана.
- 6.2 Ажил олгогч нь химийн болон биологийн бодистой харьцан ажилладаг ажилтанд тухайн бодис бүрийн физик химийн шинж чанар, тэдгээртэй ажиллах, хадгалах, тээвэрлэх, устгахад мөрдөх аюулгүй ажиллагааны зохих мэдлэгийг эзэмшүүлсэн байна.
- 6.3 Химийн хорт бодисыг ангилах, хаяглах ба тэмдэглэх, аюулгүй ажиллагааны картын хөтлөлт, ажлын бүсийн агаарт байх химийн хорт бодисын хэмжээг хязгаарлахад тавих шаардлага нь стандарт “Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага”-тай нийцсэн байна.

**7 Гал гарах болон тэсэрч дэлбэрэх бодисыг ашиглах үед тавих шаардлага**

- 7.1 Гал гарах болон тэсэрч дэлбэрэх бодисыг ашиглах түүнийг зөөх, тээвэрлэх, хадгалах, устгах үед тухайн бодисын аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл ахуйн холбогдох дүрэм зааврыг мөрдөн ажиллана.
- 7.2 Гарч болзошгүй галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал гарсан үед богино хугацаанд унтраах багаж хэрэгсэл, галын хорыг зохих газар нь байрлуулж түүнийг хэрэглэх ашиглах талаар ажилтанд зохих мэдлэгийг олгоно.

**ТӨГСӨВ.**